Төв аймгийн насанд хүрэгчдийн дунд халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлох судалгаа

М.Хонгорзул[1], Ц.Нямсүрэн[2]

[1]НЭМС, Урьдчилан сэргийлэх анагаах ухааны тэнхим,
[2]НЭМС, Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхим
Email: nyamsuren@mnums.edu.mn, Утас: 91199633

Түлхүүр үг:
Халдварт бус өвчин
Эрсдэлт хүчин зүйл

Товч утга: Энэхүү судалгаан нь Төв аймгийн насанд хүрэгчдийн халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын түвшин, иргэдийн мэдлэг, хандлагыг тодорхойлох зорилгоор Төв аймгийн 26 сумдын нийт 2824 хүнийг хамруулан хийсэн нэгэн агшны судалгаа юм. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын аргачлалын дагуу халдварт бус өвчин (ХБӨ)-ний анхдагч болон завсрын эрсдэлт хүчин зүйлсээс өдөр бүр тогтмол тамхи татах, хоногт 5 нэгжээс бага жимс, хүнсний ногоо хэрэглэх, хөдөлгөөний хомсдолтой, илүүдэл жин ба таргалалттай, цусны даралт ихсэлт зэрэг нийтлэг тохиолдох 5 эрсдэлт хүчин зүйлс хавсран илрэх тохиолдлыг асуумж болон хэмжилтийн 2 шатлалт аргаар судалж үнэлсэн болно. Судалгааны үр дүнд Төв аймгийн хүн амын дийлэнх буюу 66 хувь нь ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй бүлэгт, 17 хувь нь өндөр эрсдэлтэй бүлэгт хамрагдсан байна. Энэ нь хүн амын дунд халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалт их байгааг мөн үүний талаарх хүмүүсийн мэдлэг хангалтгүй, амьдралын буруу дадал, хандлагатайг харуулж байна.

Үндэслэл: Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлс нь Монголын хот хөдөөгийн хүн амд тархалтаараа ойролцоо байгаа боловч хот суурин газрын хүн амын дунд эрсдэлт хүчин зүйлс илүүтэй нөлөөлж байна[1]. Манай улсад үүний таллаарх судалгааны дүн харьцангуй их байгаа боловч Төв аймгийн насанд хүрэгчдийн халдварт бус өвчинд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийг орон нутгийн түвшинд судлах хэрэгцээ байсаар байна. Иймд халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг Төв аймгийн зорилтот бүлгийн хүн амын дунд тогтоож, улмаар нотолгоонд суурилсан мэдээллийг бүрдүүлж, бодлогын баримт бичгийг төлөвлөх, боловсруулахад ашиглах үүднээс энэхүү судалгааг хийлээнэ.

Зорилго: Төв аймгийн насанд хүрэгчдийн халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын түвшин, иргэдийн мэдлэг, дадал, хандлагыг тодорхойлох зорилоготой.

Зорилт: 18-65 насны буюу насанд хүрсэн иргэдийн дунд халдварт бус өвчний анхдагч болон завсрын эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг тодорхойлох, орон нутгийн иргэдийн халдварт бус өвчний талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох зорилтуудыг тавьсан.

Арга аргачлал: Судалгаанд Төв аймгийн 26 сумдын 18-65 насны нийт хүн амыг төлөөлөхүйц судалгааны хүн амыг сонгож судалгааг эпидемиологийн агшингийн судалгааны загвараар хийлээнэ. Төв аймгаас судалгаанд хамрагдсан 28234 хүнээс (ДЭМБ)-ын ХБӨ-ний тандалтын тогтолцооны “Шаталсан судалгаа”-ны арга, аргачлалын дагуу ДЭМБ-ын зөвлөмжийг үндэслэн эрсдэлт хүчин зүйлсийн түвшинг 2 шатлалтайгаар судалсан юм. 1-р шат: Асуумж судалгааны арга 2-р шат: Бие махбодийн хэмжилтийн арга

Үр дүн: Судалгаанд хамрагдсан нийт насанд хүрсэн 2824 хүний материалд боловсруулалт хийж үр дүнг гаргав. Хүн амын 24 хувь нь одоогоор архи, согтууруулах ундаа хэрэглэгчид, эдний 66.5 хувь нь эрэгтэйчүүд, 33.5 хувь нь эмэгтэйчүүд байв. Архи согтууруулах ундаа хэрэглэсэн нийт хүмүүс нэг удаад архи, согтууруулах уудааг уухдаа 6 ба түүнээс олон стандарт уултаар хэтрүүлэн уусан эрсдэлт зан үйлтэй байна. Согтууруулах ундаа хэрэглэдэг дийлэнх оролцогч буюу 85.2 хувь нь архины хэрэглээний асуудлаа гадаад хүчин зүйлд хамаатуулах хандлагатай,

30 орчим хувь нь согтууруулах ундааны хэрэглээгээ өөрчлөх эрмэлзэлгүй байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Архины хэрэглээ (хүйсээр)

Архины хэрэглээ	Нийт	эрэгтэй	эмэгтэй
Сүүлийн нэг сард архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын эзлэх хувь	24	34	15
Сүүлийн нэг сард архи, согтууруулах ундааг 7 хоногийн 5 ба түүнээс олон өдрүүдэд хэрэглэсэн хүн амын эзлэх хувь	1.5	1.6	1.3
Сүүлийн 1 сард, нэг удаад хэрэглэсэн архи, согтууруулах ундааны стандарт уултын дундаж тоо	9.1	10.2	5.2
Согтууруулах ундааг хэрэглэдэг шалтгаанаа гадаад хүчин зүйлд хамаатуулж буй хүн амын эзлэх хувь	86.7	82.2	91.2
Архины хор уршгийн талаар мэдэхгүй гэж хариулсан хүн амын эзлэх хувь	2.7	2.7	2.6
Согтууруулах ундаа уухаа болих талаар боддогүй хүмүүсийн эзлэх хувь	28.6	27.9	29.4
Уухаа болиод 6-аас дээш сар болж байгаа хүмүүсийн эзлэх хувь	4.5	3.9	5.1

Судалгааны дүнгээр нийт хүн амын 19.6 хувь, эрэгтэйчүүдийн 28.7 хувь, эмэгтэйчүүдийн 11.1 хувь тамхи тамхи татдаг байна. Тамхи хэрэглэгчдийн ихэнх нь (94.7%) өдөр бүр тогтмол татдаг байв. Судалгаанд хамрагдсан 10 хүн тутмын 4 нь (41.4%) гэрийн дотоод орчинд, 4 хүн тутмын 1 нь (25.7%) ажлын байрандаа дам тамхидалтад өртөж байна. Одоогоорийн байдлаар нийт тамхи хэрэглэж буй хүн амын дэг хүмүүсийн 35.6 хувь нь тамхинаас гарах оролдлого хийсэн. Харин 50 орчим хувь нь тамхины хэрэглээний асуудлаа аас ойлгож мэдсэн, зан үйлээ өөрчлөх санаа сэдэл бүхий байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Тамхины хэрэглээ (Хүйсээр)

Тамхины хэрэглээ	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
Тамхи татдаг хүн амын эзлэх хувь	19.6	28.7	11.1
Өдөр бүр тамхи татдаг хүн амын эзлэх хувь	94.7	-	-
Тамхи татаж эхэлсэн дундаж нас (жилээр)	20	20	22
Өдөрт татдаг тамхины тоо	10.3	10.5	9
Тамхинаас гарах оролдлого хийсэн хүн амын эзлэх хувь	35.6	36.3	29.7
Тамхинаас гарах талаар боддогүй хүн амын эзлэх хувь	42.5	38.9	46.2
Тамхинаас гараад 6-аас дээш сар болж байгаа хүн амын эзлэх хувь	0.9	0.4	1.5

Төв аймгийн нийт хүн ам хоногт дунджаар 3 нэгж жимс, 2.8 нэгж хүнсний ногоо хэрэглэж байгаа нь ДЭМБ-ын зөвлөмж хэмжээнээс 1 нэгжээр доогуур байна. Хүн амын дийлэнх буюу 88.7 хувь нь хоногт 5 нэгжээс бага жимс, хүнсний ногоо хэрэглэж байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Хүнсний хэрэглээ (хүйсээр)

Жимс, ногооны хэрэглээ	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
Жимс хэрэглэсэн өдрийн дундаж тоо	2.3	2.2	2.4
Хоногт хэрэглэсэн жимсний дундаж хэмжээ, нэгжээр	3	3.3	2.8
Ногоо хэрэглэсэн өдрийн дундаж тоо	5.1	5.1	5.1
Хоногт хэрэглэсэн ногооны дундаж хэмжээ, нэгжээр	2.8	3.7	2.9
Хоногт дунджаар 5 нэгжээс бага жимс, ногоо хэрэглэсэн хүн амын эзлэх хувь	88.7	-	-
Өдөр бүр тосонд хайрсан боорцог, бин хэрэглэдэг хүн амын эзлэх хувь	46.2	-	-
Давс хэтрүүлэх хэрэглэх хандлагатай хүн амын эзлэх хувь	10.7	-	-
Зөв хооллолтын талаарх мэдлэг бага, мэдэхгүй хүмүүсийн эзлэх хувь	23	26	20.3

Нийт хүн амын 55 хувь нь хөдөлгөөний хомсдолтой эрсдэлт бүлэгт багтаж байгаа бөгөөд судалгааны хүрээний хүн амын 21.9 хувь нь биеийн хүч дунд зэрэг шаардсан хөдөлгөөнийг хийдэг, мөн нийт хүмүүсийн 23.1 хувь биеийн хүч их шаардсан хөдөлгөөн хийдэг болохыг судалгаагаар илрүүлэв. Түүнчлэн судалгаанд хамрагдагсдын 50 хувьд нь ажлын байр эсвэл гэртээ идвэхтидэвхтэй хөдөлгөөн хийх, спортоор хичээллэх нөхцөл байдаггүй байна (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Хөдөлгөөний идэвхи (хүйсээр)

Хөдөлгөөний идэвхи	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
Идэвхтэй хөдөлгөөн хийдэггүй хүн амын эзлэх хувь	65	64.6	65.4
Биеийн хүч их шаардсан хөдөлгөөн хийдэггүй хүн амын эзлэх хувь	55	51	58.2
Нэг газраас нөгөө рүү ядаж 10 минут явганаар болон дугуйгаар явдаг хүн амын эзлэх хувь	69	-	-

Хүн амын биеийн жингийн индекс (БЖИ)-ийн БЖИ-ийн эрсдэлийн үнэлгээгээр нийт хүн амын 34.3 хувь нь илүүдэл жинтэй, 19.9 хувь нь таргалалттай байна. Илүүдэл жин ба таргалалтын тархалт нас ахих тутам нэмэгдэх хандлагатай байв. Бүсэлхийн тойргийн байдлаар эрсдэлийн үнэлгээгээр нийт хүн амын 52.7 хувь, эрэгтэйчүүдийн 28.1 хувь, эмэгтэйчүүдийн 74.3 хувь нь тус тус төвийн таргалалттай байгааг тогтоов.

Артерийн даралтын (АД) хэмжилтээр нийт хүмүүсийн 78.1 хувь нь хэвийн, 21.9 хувь нь АД ихсэлттэй байлаа. АД ихсэлттэй хүн амын эрэгтэй, эмэгтэй хүйсийн эзлэх хувь ялгаагүй харин нийт эрэгтэйчүүдийн 23.6 хувь нь, эмэгтэйчүүдийн 20.4 хувь нь АД ихсэлттэй байв. Судалгаанд хамрагдагсдын 29.1 хувь нь артерийн даралтаа урьд өмнө огт хэмжүүлж байгаагүй, артерийн даралт ихсэлттэй 3 хүн тутмын хоёр нь даралт бууруулах эм хэрэглэдэг. Нийт хүн амын 59 хувь нь урьд өмнө нь урьдчилан сэргийлэх үзлэгээр цусны сахараа тодорхойлуулж байгаагүй. Сахар ихэссэн гэж оношлогдсон хүмүүсийн ердөө 27-33 хувь нь л сахарын хэмжээгээ бууруулах гэж эм бэлдмэл хэрэглэж, эмчилгээ хийлгэсэн байна (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Бие махбодын хэмжилт

Бие махбодын хэмжилт	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
Биеийн æингийн индекс (БЖИ)-ийн дундаж хэмжээ (кг/м^2)	26.2	26.2	26.2
Илүүдэл жин ба таргалалттай хүн амын эзлэх хувь	54.2	55.2	53.3
А. Үүнээс илүүдэл жинтэй хүн амын эзлэх хувь	34.3	36.2	19
Б. Үүнээс таргалалттай хүн амын эзлэх хувь	19.9	32.7	20.6
Бүсэлхийн тойргын дундаж хэмжээ, см	-	89.3	85.8
Ташааны тойргын дундаж хэмжээ, см	-	94.5	94.2
Төвийн таргалалттай хүн амын эзлэх хувь	52.7	28.1	74.3
Артерийн дарат ихэссэн хүн амын эзлэх хувь	21.8	23.6	25.5

Эмэгтэйчүүдийн 61.4 хувь нь умайн хүзүүний өмөнг эрт илрүүлэх шинжилгээнд хамрагджээ. Тэдний 67.2 хувь нь эрүүл мэндийн ажилтнаар хөхөө шинжүүлсэн байна. Нийт эмэгтэйчүүдийн 45 хувь нь ХБӨ-өөс урьдчилан сэргийлж болно гэдгийг мэддэг ч хараахан арга хэмжээ аваагүй байна.

Хүн амын 56.4 хувь нь тээврийн хэрэгсэл жолоодох буюу машинаар зорчихдоо суудлын даруулга хэрэглэдэггүй, 42.4 хувь нь мотоцикл, дугуйгаар зорчих эсвэл жолоодохдоо хамгаалалтын малгай байнга хэрэглэдэггүй эрсдэлт зан үйлтэй. Судалгааны хүн амын 3.7 хувь нь ЗТО-д өртсөн, үүнд эмэгтэйчүүдийн эзлэх хувь харьцангуй их байв. Судалгааны хүрээний хүн амын 3.3 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд зам тээврийн бус шалтгаанаар гэмтэж, эмнэлгийн тусламж авсан бөгөөд унаж бэртсэн, цохиулсан, түлэгдсэн шалтгаан давамгайлж байна (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Осол, гэмтэл (хүйсээр)

Осол, гэмтэл	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
Сүүлийн 12 сарын хугацаанд ЗТО-д орсон хүн амын эзлэх хувь	3.7	3.6	3.8
Тээврийн хэрэгсэл жолоодох эсвэл зорчихдоо суудлын даруулга огт хэрэглээгүй хүн амын эзлэх хувь	56.4	54.5	58.1
Мотоцикл, дугуйгаар зорчих эсвэл жолоодохдоо хамгаалалтын дуулга хэрэглэдэггүй хүн амын эзлэх хувь	42.4	49	36.7

Нийтлэг тохиолдох 5 эрсдэлт хүчин зүйлээр үнэлэхэд нийт судалгаанд хамрагдсан хүн амын 16.8 хувь нь ХБӨ-өөр өвчлөх эрсдэлгүй, 66.1 хувь нь эрсдэлтэй, 17.1 хувь нь өндөр эрсдэлтэй байв. Хүйсийн хувьд өндөр эрсдэлтэй эрэгтэй хүмүүс эмэгтэйчүүдээс 3.5 дахин их, насны бүлгийн хувьд 25-аас дээш насныхан илүү өндөр эрсдэлтэй байна (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Эрсдэлт хүчин зүйлийн үнэлгээ (хүйсээр)

Эрсдэлт хүчин зүйлийн үнэлгээ	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
Нийтлэг эрсдэлт хүчин зүйл огт илрээгүй хүн амын эзлэх хувь	17	9.7	23.1
Нийтлэг эрсдэлт хүчин зүйл 1-2 илэрсэн хүн амын эзлэх хувь	66	61.8	69.7
Нийтлэг эрсдэлт хүчин зүйл 3 ба түүнээс олон илэрсэн хүн амын эзлэх хувь	17	28.3	7.2

Дүгнэлт: Төв аймгийн хүн амын дийлэнх буюу 66 хувь нь ХБӨ-өөр өвчлөх эрсдэлтэй бүлэгт, 17 хувь нь өндөр эрсдэлтэй бүлэгт хамрагдан, ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлийн 3 ба түүнээс дээш нь амьдралыг хэв маягт байгаа нь хүн амын дунд архи, тамхины хэрэглээ өндөр, жимс, хүнсний ногооны хэрэглээ хангалтгүй, хөдөлгөөний хомсдолтой, илүүдэл жин ба таргалалттай, цусны даралт ихсэлттэй хүмүүс их байгааг мөн үүний талаарх мэдлэг хангалтгүйг харуулж байна.

Талархал: Төв аймгийн эрүүл мэндийн газарт төв аймгийг төлөөхүйц хүн амыг сонгон хамруулж судалгааны асуумж, мэдээллийг цаг тухайд нь мэдээлсэнд талархал илэрхийлье.

Ном зүй:

1. *Төв аймгийн эрүүл мэндийн газар. Төв аймгийн эрүүл мэндийн газар. http://emg.to.gov.mn/. [Onlineонлайн] 2018 оны.*
2. *ЭМЯ. ДЭМБ. НЭМХ. Халдварт бус өвчин ба амьдралын эрүүл хэв маяг сургалтын гарын авлага. Улаанбаатар .: ., 2006.*
3. *НЭМҮТ. Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын түвшин тогтоох судалгаа. Улаанбаатар : ., . 2006.*
4. *Ш.Оюун-Эрдэнэ. Халдварт бус өвчний зарим анхдагч болон завсрын эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгаа. Улаанбаатар : ., . 2010.*
5. *ЭМХТ. WHO. Эрүүл мэндийн үзүүлэлт. Улаанбаатар : ., . 2018.*
6. *ЭМЯ, ДЭМБ, НЭМС. Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын түвшин тогтоох шатчилсан судалгаа. Улаанбаатар : ., . 2010.*
7. *Ч.Пүрвээ. Халдварт бус өвчний талаарх оюутнуудын мэдлэгийн түвшинг тодорхойлох судалгаа. Улаанбаатар : ., . 2013.*
8. *Д.Мягмарцэрэн. Чихрийн шижин өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгаа. Улаанбаатар : ., . 2009.*
9. *Х.Чингэрэл. Монгол улсын 40-өөс дээш насны хүн амын дундах артерийн даралт ихсэлт ба зүрхний бах өвчний тархалт зарим эрсдэлт хүчин зүйлсийн судалгаа. Улаанбаатар : .,. 2011.*
10. *ММСС, ЭМЯ. Халдварт бус өвчний талаарх хүн амын мэдлэг, хандлага, дадал. Улаанбаатар. : s.n., 2011. pp. 11-15.*
11. *Ч.Оргилтуяа. ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлсийн чиглэлээр өрхийн эмч, үйлчлүүлэгчдийн хооронд үүссэн зөрчилийг судалсан нь. Улаанбаатар : s.n.,. 2015.*
12. *ЭМЯ, ДЭМБ, ММСС, НЭМҮТ . Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын шаталсан судалгаа . Улаанбаатар : ., . 2013.*

Risk factors for non-communicable disease among adolescents in tov province

M.Khongorzul[1], Ts.Nyamsuren[2]

[1]Prevention science department,
[2]Department of Health Social Work and Social Sciences
Email: nyamsuren@mnums.edu.mn, Phone: 91199633

Overview: This study aims to determine the prevalence of risk factors for non-communicable diseases, therefore exploring knowledge and attitude among adolescents in the tov province. It is a cross-sectional study that was conducted among 2824 adults of 26 sums of Tov province. The study comprised 2 steps of the questionnaire and physical measurement to estimate the co-occurrence of common 5 risk behaviors including tobacco use, daily consumption of less than 5 serving fruit and vegetables, physical inactivity, overweight and obesity, high blood pressures according to WHO surveillance of risk factors for non-communicable disease. The result was 66% of Tow province population were classified into NCD's moderate risk group, 17% were in a high-risk group. This result shows the prevalence of non-communicable disease is high among adults, therefore their knowledge about NCD is not enough and most of them have an unhealthy lifestyle.